

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

[Захиалагч болон үнэлгээний хороо нь худалдан авах барааны техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай барааг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендер шалгаруулалтын баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.*
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах барааны шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.*
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөвт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.*
- Тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана. Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай.*
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.*
- Бараа материалын, техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.*

Зураг, төсөл

Шаардлагатай бол барааны эскиз, зургийг хавсаргана.

Шалгалт, туршилт

[Захиалагч оролцогчоос нийлүүлэх гэж буй бараанд үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилт хийсэн болохыг нотлох баримт, үүнтэй холбоотой мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.

Шаардлагатай тохиолдолд захиалагч загвар, дээжийг шалгаж, туршиж болох ба шалгалт, туршилт хийсний үр дүнд тухайн загвар, дээжийн үндсэн шинж чанар алдагдсан, зориулалтын дагуу дахин ашиглах боломжгүй болсон тохиолдолд оролцогчид буцааж олгохгүй тухай техникийн тодорхойлолтод заана. Бусад тохиолдолд гэрээ байгуулсны дараа шалгарсан оролцогчийн загвар, дээжээс бусад загвар, дээжийг буцааж олгоно.

Загвар, дээжийг хэрхэн шалгах, турших тухай тодорхой заана.]

Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь доор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Багц №1 Титэм судсан дотуурх хэт авиан оношилгооны аппаратын иж бүрдэл (Intravascular ultrasound imaging system-IVUS) худалдан авах

Д/д	Тоног төхөөрөмжийн нэр	Техникийн тодорхойлолт
1	Титэм судсан дотуурх хэт авиан оношилгооны аппаратын иж бүрдэл (Intravascular ultrasound imaging system-IVUS) /1 иж бүрдэл аппарат/	<p>I. Аппаратын иж бүрдэл: Зүрхний титэм судасны нарийсал, судасны дисплази зэрэг оношилгоо, эмчилгээ хийхэд шаардлагатай иж бүрэн тоноглогдсон үндсэн аппарат</p> <p>1.1 Patient interface module 1.2 Physiology patient interface module 1.3 Аппаратыг зөөвөрлөх, принтер болон дагалдах хэрэгслүүдийг байрлуулах боломжтой, түгжээтэй дугуй бүхий суурь 1.4 1500W болон түүнээс дээш чадалтай тог тогтворжуулах, тог барих зориулалттай смарт UPS 1.5 Принтер 1.6 Хяналтын дэлгэц /утасгүй сүлжээгээр холбогдох боломжтой, мэдрэгч бүхий дэлгэц/-19"-ээс багагүй хэмжээтэй, 1280 x 1024 түүнээс дээш нягтралтай байх 1.7 Процессор i7 intel CPU 8th Gen түүнээс дээш байх</p> <p>II. Программ, үндсэн үзүүлэлтүүд: 2.1 License windows 10 үйлдлийн системтэй эсвэл түүнтэй дүйцэхүйц лицензтэй үйлдлийн системтэй байх. 2.2 Digital IVUS imaging 2.3 Coronary imaging 2.4 Peripheral imaging 2.5 ChromaFlo IVUS эсвэл түүнтэй дүйцэхүйц судсыг автоматаар дүгнэж анализ хийдэг байх 2.6 High resolution Rotational IVUS imaging (титэм болон захын артериудын дүрслэл гаргах, тооцоолол хийх боломжтой байх) 2.7 FFR modality (ишемийг хурдан оношилох, үнэлэх боломжтой байх) 2.8 iFR modality Spot/Pullback эсвэл түүнтэй дүйцэхүйц үзүүлэлттэй байх. (Ишемийг хурдан оношилох, үнэлэх боломжтой байх, ангиографийн шинжилгээний үед эмчилгээний шийдвэр гаргахад шаардлагатай физиологийн үзүүлэлтүүд гаргаж өгдөг байх) 2.9 IFR scout modality эсвэл түүнтэй дүйцэхүйц байх.</p> <p>III. Coronary imaging catheters 3.1 20МГц- 60МГц хүртэл импульстай байна, Rx системийн дижитал IVUS катетер (2D хэт авиан дүрслэл, нэгэн зэрэг цусны урсгалын динамик болон хэт авиан дүрслэл, виртуал гистологи зэргийг хийх боломжтой байх, 30 ширхэг нэг удаагийн ариун савлагаатай байх)</p>

		<p>3.2 Автомат катетр ухрах систем (Auto-pullback catheter system)</p> <p>IV. Coronary pressure and flow wires</p> <p>4.1 Pressure guide wire эсвэл түүнтэй дүйцэхүйц байх. /2 горимд ашиглах боломжтой байх: дээд хэмжээний гиперемии болгох эмийн бэлдмэлтэй цуг хэрэглэх горим FFR болон эмгүй горим iFR/-30 ширхэг</p> <p>V. Цахилгааны үзүүлэлт</p> <p>5.1 AC – 100-240V, 50/60Hz, ойролцоогоор 250W түүнээс дээш чадалтай байх</p> <p>VI. Мэдээлэл хадгалалт ба боловсруулалт</p> <p>6.1 Хатуу дискний багтаамж: 1 TB болон түүнээс дээш багтаамжтай байх</p> <p>6.2 Дижитал архивын сонголтууд: Local, DVD, DICOM 3.0 network, USB (.jpg)</p> <p>VII. Тавигдах ерөнхий шаардлага:</p> <ul style="list-style-type: none">✓ Эмнэлгийн тоног төхөөрөмж нь технологийн хувьд орчин үеийн, дэвшилтэт технологи байхын сацуу ашиглахад энгийн, ажиллагааг хянах боломжтой, олон улсын бүтээгдэхүүний чанарын CE, FDA, ISO, TUV зэрэг стандартуудын аль нэгийг хангасан байх✓ Тухайн тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний сургалтыг холбогдох эмч, инженер, мэргэжилтнүүдэд зохион байгуулах✓ Бүрэн ажиллагааг хангахын тулд бараанд зайлшгүй шаардлагатай бүх нэмэлт ба дагалдах хэрэгслүүдийг хамтад нь санал болгох /үнэ, part number/✓ Баталгаат хугацаа 2 жил түүнээс дээш байх ба баталгаат хугацааны засвар үйлчилгээг ханган нийлүүлэгч байгууллага хариуцаж, баталгаат засварын гэрээг хүлээн авагч байгууллагатай тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгөх үед байгуулах.✓ Баталгаат хугацаа дууссаны дараа сэлбэг материалаар хангах боломжтой байх үнийн саналыг тоног төхөөрөмж тус бүр дээр дагалдуулсан байх.✓ Ашиглалтын болон засвар үйлчилгээний дараах гарын авлагыг англи, монгол хэл дээр тухайн аппарат, тоног төхөөрөмжийг дагалдуулж өгөх<ul style="list-style-type: none">• хэрэглэгчийн гарын авлага• засвар үйлчилгээний гарын авлага• Баталгаат хугацаанд хийх техник үйлчилгээний график /өдөр тутам, 7 хоног, сарын, шалгах хуудас/ <p>Дээрх шаардлагыг хангах, эсвэл түүнтэй дүйцэхүйц байхыг нотлох баримтыг хавсарган ирүүлнэ.</p>
--	--	--

АШИГЛАЛТЫН ХУГАЦААНЫ ӨРТӨГ ТООЦОХ ТАЙЛБАР, АРГАЧЛАЛ

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4.1.3 “ашиглалтын хугацааны өртөг” гэж харьцуулах үнэ дээр ашиглалтын хугацаанд гарах зардлыг харгалзан тооцсон тоон утгыг хэлнэ.
2. Хуулийн 11.4 дүгээр зүйл “Захиалагч шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлэх доор дурдсан үндсэн шалгуурын аль нэгийг сонгон тендер шалгаруулалтын баримт бичигт заана”:
 - 11.4.1.харьцуулах үнэ;
 - 11.4.2.ашиглалтын хугацааны өртөг;
 - 11.4.3.чанар ба үнийн хосолмол. тооцох шалгуурыг сонгож тендер шалгаруулалтын баримт бичигт заана.
3. Хуулийн 27 дугаар зүйлийн 27.5 “Тендерийг энэ хуулийн 11.4.1-д зааснаар үнэлэхэд харьцуулах үнийг, энэ хуулийн 11.4.2-т зааснаар үнэлэхэд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан аргачлал, зааврын дагуу тооцсон үнийг тус тус өсөх дарааллаар эрэмбэлж, эхэнд эрэмбэлэгдсэн тендерийг хамгийн сайн тендер гэж үзнэ”.

Ашиглалтын хугацааны өртөг

Хүснэгт 1

№	Зардлын төрөл	Нийт сая.төг	Жил 1				Жил 2				Жил3.....10			
			Тоо ширхэг	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Нийт үнэ	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Нийт үнэ	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Ашиглалтын хугацаанд шаардлагатай өндөр өртөгтэй эм, эмнэлгийн хэрэгсэл													
	...													
	Зардал А													

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа (10)жилд зарцуулагдах материалын дэлгэрэнгүй зардлын тооцооллыг Хүснэгт 1-ийн дагуу зардлын нэрийг өндөр өртөгтийн нэршлээр бүрэн бөглөж ирүүлэх; Нийт өртгийг өндөр өртөгтэй эм, эмнэлгийн хэрэгсэл бүрээр жилд 200 тохиолдлоор тооцон гаргах.

Тоног төхөөрөмж худалдан авах суурилуулалттай холбоотой өртөг

Хүснэгт 2

№	Тоног төхөөрөмж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Тоног төхөөрөмжийн үнэ			
2	Тээвэр, хүргэлт			
3	Суурилуулалт			
4	Сургалт зохион байгуулах			
5	Баталгаат засвар 2 жил (төлөвлөгөөт үзлэг, оношилгоо)			
	Зардал В			

Эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах, суурилуулалттай холбоотой зардлыг дэлгэрэнгүй тооцож ирүүлэх.

1. Үнэлгээ хийх аргачлал:

Д/д	Багцын мэдээлэл	Тохиолдлын тоо	Аргачлал
1	Титэм судсан дотуурх хэт авиан оношилгоо	200	$\frac{\text{Хамгийн бага харьцуулах үнэ (ЗардалА)}*50}{\text{Зардал А}} + \frac{\text{Хамгийн бага харьцуулах үнэ(ЗардалВ)}*50}{\text{Зардал В}} = \text{Нийт оноо}$

***Тендерийг үнэлэхдээ Дээрх үнэлгээний аргачлалын дагуу тооцож, оноог өсөх дарааллар эрэмбэлж, эхэнд үнэлэгдсэн тендерийг хамгийн сайн тендер гэж үзнэ.**